

Улаанбаатар хотын Ерөнхий
менежерийн 2023 оны 05 дугаар
сарын 26-ны өдрийн 11:13 дугаар
тушаалын 20 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдэх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба

Нэгжийн нэр:

Дугуйн ба явган хүний зам,
тохижилтын хэлтэс

Албан тушаалын нэр:

Хот чимэглэл, гадна зар сурталчилгааны
асуудал хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Чингэлтэй дүүрэг 1 хороо
Ц.Жигжиджавын гудамж 9, Хангарди
ордон

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Зар сурталчилгааны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хот тохижилтын шаардлагад нийцсэн, олон улсын дэвшилтэт технологи бүхий хот чимэглэл, гадна зар сурталчилгааны байгууламжийг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих, орон зай төлөвлөлт, тавигдах шаардлага, өнгө үзэмж, аюулгүй байдлыг хангуулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулах, хот чимэглэл, гадна зар сурталчилгааны байгууламжийн хураамжийг төвлөрүүлэх тогтолцоог сайжруулах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Төрийн албаны зөвлөлийн
2023 оны 05 дугаар сарын
02-ны өдрийн 153 дугаар
тотоолын 20 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Хууль тогтоомжийн нэр огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба

Дугуйн ба явган хүний зам, тохижилтын хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Хот чимэглэл, гадна зар сурталчилгааны асуудал хариуцсан мэргэжилтэн

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг

Ажлын байрны албан ёсны байршил

Ажлын өдөр 8 цаг

Чингэлтэй дүүрэг, 1 хороо Ц.Жигжиджавын гудамж 9, Хангарди ордон

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Зар сурталчилгааны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хот тохижилтын шаардлагад нийцсэн, олон улсын дэвшилтээ технологи бүхий хот чимэглэл, гадна зар сурталчилгааны байгууламжийг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих, орон зайд төлөвлөлт, тавигдах шаардлага, өнгө үзэмж, аюулгүй байдлыг хангуулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулах, хот чимэглэл, гадна зар сурталчилгааны байгууламжийн хураамжийг төвлөрүүлэх тогтолцоог сайжруулах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:


- 1.Холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, тайлагнах;
- 2.Хот тохиижилтын шаардлагад нийцсэн, олон улсын дэвшилтэт технологи бүхий хот чимэглэл, гадна зар сурталчилгааны байгууламжийг төлөвлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих, орон зай төлөвлөлт, тавигдах шаардлага, өнгө үзэмж, аюулгүй байдлыг хангуулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход санал өгөх, хот чимэглэл, гадна зар сурталчилгааны байгууламжийн хураамжийг төвлөрүүлэх тогтолцоог сайжруулах, мэдээллийн сан бүрдүүлэх, тайлагнах;
- 3.Нэгжийн үйл ажиллагаанд оролцож, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;
- 4.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах-Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.Эрхэлсэн ажлын хүрээнд холбогдох хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах;</p> <p>2.Төрийн албаны тухай хууль болон төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрэм журам, байгууллагын дотоод журам, бусад төрийн албаны стандартыг мөрдөж хэрэгжүүлэх;</p> <p>3.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон Авлигын эсрэг хууль тогтоомжийг мөрдөх, хэрэгжилтийг хангах;</p> <p>4.Дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлт, тайлан мэдээ, цаг үеийн чанартай мэдээ мэдээллийн биелэлтийг цаг хугацаанд нь гаргаж, холбогдох газарт хүргүүлэх.</p>	<p>Хууль эрх зүйн акт, дүрэм журмын хүрээнд зөрчилгүй ажилласан байна.</p> <p>Төрийн албаны тухай хууль болон бусад стандарт дүрэм, журмыг зөрчөөгүйг нотлох дүгнэлт гаргасан байна.</p> <p>Эрх бүхий албан тушаалтанд ХАСХОМ-ийг өгсөн байдал, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.</p> <p>Хэрэгжилтийн хувиар.</p>	Г
	1.Хот байгуулалт, мөрдөгдөж буй хууль журамд нийцүүлэн олон	Хот төлөвлөлт, хот байгуулалтын шаардлагад нийцсэн	Г



	улсын дэвшилтэт технологи бүхий хот чимэглэл, гадна зар сурталчилгааны байгууламжийг төлөвлөх, бий болгох;	тохижилтын ажлыг төлөвлөсөн байна.	
2 дугаар зорилтын хүрээнд	2.Хотын гадна зар сурталчилгаа, хот чимэглэлийн талаар баримтлах бодлого боловсруулахад оролцох, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоог сайжруулах ажлыг хариуцан гүйцэтгэх;	Хууль эрх зүйн акт, дүрэм журмын хүрээнд зөрчилгүй ажилласан байна.	Г
	3.Хотын гадна зар сурталчилгаа, хот чимэглэлийн талаар баримтлах бодлого, зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, тухайн жилд хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, биелэлтийг хангуулж ажиллах, хяналт тавих;	Төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг хангуулж, хяналт тавьсан байна.	Г, Х
	4.Дүүрэг, харьяа байгууллагуудын хэтийн төлөв, зорилт, жилийн төлөвлөгөөг боловсруулахад Хотын зар сурталчилгаа, хот чимэглэлийн талаар баримтлах ажлын чиглэлээр санал өгч, хэрэгжилтэд хяналт тавих;	Шаардлагатай дүрэм журмыг боловсруулж хяналт тавьж, хэрэгжүүлсэн байна.	Г, Х
	5.Хот чимэглэл, гадна зар сурталчилгааны байгууламжийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, өнгө үзэмж, аюулгүй байдлыг хангуулах ажлыг хариуцах;	Шалгалт явуулсан үр дүнгийн хэрэгжилтийн хувиар илэрхийлэгдэнэ.	Х
	6.Хот чимэглэл, гадна зар сурталчилгааны байгууламжийн хураамжийг төвлөрүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэх;	Мэдээллийн сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар илэрхийлэгдэнэ.	Г
	7.Хот чимэглэл, гадна зар сурталчилгааны байгууламж, байгууллага аж ахуйн нэгжийн гадна хаяг, мэдээллийн байгууламжийн орон зайн	Хот төлөвлөлт, хот байгуулалтын шаардлагад нийцсэн тохижилтын ажлыг төлөвлөсөн байна.	Г 

	төлөвлөлт, тавигдах шаардлагын хэрэгжилтэд хяналт тавих, зөрчил дутагдлыг арилгах;		
	8. Гудамж талбайн нэр, орон зайн хаяг, орон сууц, гэр хорооллын хаягжилтын талаар хийх шаардлагатай ажлын судалгаа хийх, стандарт шаардлагад нийцүүлэн хийж гүйцэтгэх, иргэдийн шаардлага хэрэгцээг хангах;	Хууль эрх зүйн акт, дүрэм журмын хүрээнд зөрчилгүй ажилласан байна.	Г
	9. Хотын гэрлэн чимэглэл, барилга байгууламжийн фасадны гэрэлтүүлгийг хот байгуулалт, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөж, гүйцэтгэх ажлыг зохион байгуулах.	Хот чимэглэлийн бодлого, төлөвлөлт ажил сайжирсан байна.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1. Байгууллага, нэгжээс зохион байгуулж байгаа аливаа сургалт, мэдээллийн цаг, нийгмийн бусад ажлуудад идэвхтэй оролцох;	Оролцооны хувиар хэмжигдсэн байна.	Г
	2. Хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн баримт бичгийн төсөл төлөвлөх, архивын нэгж бүрдүүлэх, байгууллага, нэгжийн өдөр тутмын дотоод үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах;		
	3. Албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хүлээсэн чиг үүрэг, удирдлага албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хуулийн хүрээнд бүрэн биелүүлж, гүйцэтгэл үр дүнг тухай бүр тайлагнах;	Төлөвлөгөө, үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувиар илэрхийлэгдсэн байна.	Г
	4. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг албан хэрэг хөтлөлтийн стандарт, журмын дагуу хуулийн	Иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Г



	хугацаанд нь шийдвэрлэж, хяналт тавих;		
	5.Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу цаасан суурьтай болон тусгай төрлийн баримтаар нөхөн бүрдүүлэлт хийх;	Архивт тогтоосон хугацаанд журмын дагуу нөхөн бүрдүүлэлт хийсэн байна.	Г
	6.Тушаал шийдвэр, цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв бодит мэдээллээр хангах, өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;	Үүрэг даалгаврыг хугацаанд гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна.	Г
	7.Нэгжийн даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, арга хэмжээний биелэлтийг хангаж, тогтоосон хугацаанд нь тайлагнах, үр дүнг үнэлж дүгнүүлэх;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлан, үнэлгээ.	Г, Х
	8.Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн баримт бичгийн төсөл төлөвлөх, архивын нэгж бүрдүүлэх, байгууллага, нэгжийн өдөр тутмын дотоод үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах.	Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн байх.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон Авлигын эсрэг хууль тогтоомжийг мөрдөх, хэрэгжилтийг хангах;	Эрх бүхий албан тушаалтанд ХАСХОМ-ийг өгсөн байдал, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.	Г
	2.Ажлын байранд хариуцсан эд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, ажлын байрны ариун цэвэр, эмх цэгц, бүрэн бүтэн байдлыг хангах;	Эд хөрөнгийн хариуцлагатай байдлын гэрээгээр зөрчилгүй ажилласан байх	Г
	3.Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага, төрийн албаны захирах,	Төрийн албаны зарчмийг баримтлах	Г



	захирагдах ёсыг баримтлан ажиллах;		
	4.Ажлын цагийн бүртгэл, цаг ашиглалт, сахилга хариуцлагыг хууль журмын хүрээнд мөрдөж ажиллах;	Ажлын цаг ашиглалтын хувиар.	Г
	5.Үүрэгт ажилдаа хариуцлагатай, санал санаачлагатай, чин сэтгэлээсээ хандаж эрхэлсэн ажлаа сурталчлах арга хэлбэрийг эрэлхийлж ажиллах;	Санаачлагатай, хариуцлагатай ажилласан байдал.	Г
	6.Хот нийтийн аж ахуйн үйл ажиллагаанд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг, үнэлгээний хороонд ажиллах.	Ажлын үр дүн, оролцоогоор	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> - Архитектур, хот төлөвлөлт /073104, 073106, 073107/; - барилгын инженер /073204/; - эдийн засаг /031101/. 		
Мэргэшил			
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг нэгтгэн дүгнэх, санал зөвлөмж боловсруулах; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - тоон судалгаанд үндэслэн харьцуулалт, шинжилгээ хийх; - тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдал, хувилбарыг тодорхойлох чадвартай байх; - бусад. 	
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - асуудлыг хууль журам, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - албан тушаалын чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - албан үргээ гүйцэтгэх явцад гарч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; 	

		<ul style="list-style-type: none"> - удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах; - хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, мэдээлэлтэй холбогдсон асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах; - бусад.
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонгой хуваалцаж хамтран ажиллах, үлгэрлэн манлайлдаг байх; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - маргаантай асуудалд хүлээцтэй ханддаг байх; - багийн амжилтыг дэмжиж бусдад таниулах; - бүтээлч санаачилгатай ажиллах; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын хувьд бусдыг үлгэрлэн манлайллах; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн орчин үеийн технологи ашиглах, мэдээллийг шуурхай солилцох; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээлэл өгөх чадвартай байх; - байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах; - харилцааны ур чадвартай байх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ


Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:
Дугуйн ба явган хүний зам, тохижилтийн хэлтсийн дарга

<u>Албан тушаалд шууд харьялан</u> <u>удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект:</u> <ul style="list-style-type: none"> - Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс, орон нутгийн харьяа газар, хэлтэс; - Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан; - Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.
--	--

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг
боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын
шийдвэр:



Албан тушаал:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА


M. Отгонбаяр

2023 оны 05 дугаар сарын 26.-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

23 0502

Шийдвэрийн огноо:

153

Дугаар:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

Шийдвэрийн огноо: 2023.05.26

Дугаар: А/143

(тамга/тэмдэг)

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА



2023 оны 05 дугаар сарын 26.-ны өдөр

